



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 02 өдөр

Дугаар A/106

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3, 13.3.6, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн тусгай зориулалтын сургалтын автомашинтай гамшгаас хамгаалах сургалтыг Дундговь, Өмнөговь аймгуудад 2019 оны 10 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
- Сургалтын удирдамжийг нэгдүгээр, оролцох бүрэлдэхүүнийг хоёрдугаар, сургалт зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Сургалтад шаардагдах 2,868,000 (хоёр сая найман зуун жаран найман мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.
- Сургалтад оролцох алба хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг баримтлан, хөдөлгөөн үйлдэх үеийн аюулгүй ажиллагаанд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган, дүнг ажлын 5 хоногт багтаан танилцуулахыг Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв (хурандаа Г.Хүрэлбаатар)-д үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.





 Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
 2019 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн
 10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117155601
 УХА0038 9077073

**ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТ, АРГА ЗҮЙН ТӨВИЙН
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИНТАЙ ӨМНӨГОВЬ, ДУНДГОВЬ
АЙМГУУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ УДИРДАМЖ**

1. Сургалтын зорилго: Гамшгаас хамгаалах сургалтын төвийн үйл ажиллагааг сурталчлах, гамшгийн эрсдэлийг бууруулах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах сургалтын төрлүүдээр анхан шатны мэдлэг олгох сургалт, дадлага зохион байгуулах.
2. Сургалтын сэдэв: Газар хөдлөлтийн аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, утаат орчноос дүрвэх, гал унтраах, амилуулах суурь тусlamж үзүүлэх.
3. Хамрах хүрээ- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, аж ахуйн нэгж байгууллага, иргэд.
4. Сургалт зохион байгуулах аймгууд: Дундговь, Өмнөговь
5. Сургалт зохион байгуулах хугацаа: 2019 оны 10 дугаар сарын 06-аас 10-ны өдөр
6. Зохион байгуулах хичээлийн сэдэв:

	Хичээлийн нэр	Ноогдох /минут/	Хэрэглэгдэхүүн	Хариуцах багш
1	Газар хөдлөлт	/50/	<ul style="list-style-type: none"> - үзүүлэн таниулах материал, - газар хөдлөлтийн танхимын сургалтын цүнх, - сургалтын автомашин 	а/д У.Амарсайхан
2	Утаат орчин	/50/	<ul style="list-style-type: none"> - утаат шашка /цагаан/, - сургалтын автомашин 	а/д У.Амарсайхан
3	Гал унтраах	/50/	<ul style="list-style-type: none"> - нунтаг гал унтраагуур, - гал унтраах техник хэрэгсэл, - сургалтын автомашин 	а/х Ш.Айжан
4	Анхан шатны тусlamж	/50/	<ul style="list-style-type: none"> -сургалтын том хүний 4, хүүхдийн 2 манекен, - бинт, - амбуу 	д/ч Г.Золжаргал
5	Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэдийн оролцоо	/40/ НИЙТ /4 цаг/	<ul style="list-style-type: none"> -Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо ба хариуцлага сэдэвт үндэсний семинарын гарын авлага 	д/ч Г.Золжаргал

--00--

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн
0//06 дугаар тушаалын хөөрдугаар хавсралт

1117155601
VXA0038 9077073

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Сургалтын удирдагч

Г.Хүрэлбаатар Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн
дарга, хурандаа,

Багшлах бүрэлдэхүүн

Ш.Айжан Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн
сургагч багш, ахмад,

У.Амарсайхан Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн
сургагч багш, ахлах дэслэгч,

Г.Золжаргал Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн
сургагч багш, дэслэгч,

С.Жанчив Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн
техникч, ахлагч,

Ю.Бат- Эрдэнэ Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн
жолооч, ахлагч

--оо--

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн
10 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

1117155601
УХА0038 9077073

ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Нэг. Зам хоногийн зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Зардлын тооцоолол				
		Хэмжих нэгж	Нэг хүний зардлын дүн	Ажиллах хүний тоо	Хугацаа /хоног/	Нийт зардлын дүн
1	Зам хоног	Хүн хоног	14,000	6	5	420,000
2	Байрны хөлс	Хүн хоног	36,000	6	5	648,000
Зам хоногийн зардлын дүн						1,068,000

Хоёр. Шатахууны зардлын тооцоо

№	Автомашины марк, улсын дугаар	Зардлын тооцоолол				
		Шаардагдах ШТМ-ын төрөл	100 км-т зарцуулах шатахууны норм	Зорчих маршрут /км/	ШТМ-ын дундаж үнэ	Шатахууны зардлын дүн
1	Сургалтын автобус 48-89 УБН	ДТ	45	1200	2,370	1,600,000
2	Суудлын автомашин 08-43 УНБ	АИ-92	9	1200	1,850	200,000
Шатахууны зардлын дүн						1,800,000
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН						2,868,000

--ооо--